



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 07 өдөр

Дугаар Б/К/7

Хэрлэн сум

Бүтэц орон тоог
шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.21, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.12, Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дахь заалт, Засгийн газрын 2020 оны 47 дугаар тогтоол, 2021 оны 377 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Засгийн газрын тохируулагч агентлаг Биеийн тамир, спортын улсын хороог Монгол улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд байгуулсантай холбогдуулан Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний Биеийн тамир, спортын газрын бүтцийг шинэчлэн баталсугай.

2.Биеийн тамир, спортын газрын бүтцийг 1-р хавсралтаар, албан тушаалын ангилал, зэрэглэл, орон тооны хязгаарыг 2-р хавсралтаар тус тус баталсугай.

3.Батлагдсан бүтцийн дагуу ажилтан, албан хаагчдыг томилох, байгууллагын дотоод журам, албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн мөрдөж ажиллахыг Биеийн тамир, спортын газар (Г.Нэргүйбаатар)-т үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (Н.Зоригтбаатар)-т үүрэг болгосугай.

5.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2020 оны Б33 тоот захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА





Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 07-ны дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНИЙ БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН БҮТЭЦ





Аймгийн Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 02-ны дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

**ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНИЙ
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН АЛБАН ТУШААЛЫН АНГИЛАЛ, ЗЭРЭГЛЭЛ
ОРОН ТООНЫ ХЯЗГААР**

№	Албан тушаал	Ангилал, зэрэглэл	Орон тоо
1	Дарга	T3-4	1
2	Биеийн тамир, спортын бодлогын хэрэгжилтийг зохицуулах спортын сургалт дасгалжуулалтын албаны дарга	T3-6	1
3	Тогтоол шийдвэрийн биелэлт, хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтэн	T3-8	1
4	Биеийн тамир, спортын бодлогын хэрэгжилт, арга хэмжээний зохион байгуулалт хариуцсан мэргэжилтэн	T3-9	1
5	Өсвөр үе, залуучууд ахмад, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, аж ахуй нэгж байгууллагын биеийн тамир, спорт хариуцсан мэргэжилтэн	T3-9	1
6	Бие бялдрын түвшин тогтоох сорил, бүртгэл мэдээлэл, сургалт, сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн	T3-9	1
7	Нягтлан бодогч	TY-8	1
8	Хүний нөөц-Архив, бичиг хэргийн ажилтан	TY-7	1
9	Үндэсний спорт, үндэсний наадам хариуцсан мэргэжилтэн	TYCB-4	1
10	Биеийн тамир, спортын статистик, цахим мэдээллийн сан хариуцсан мэргэжилтэн	TYCB-4	1
11	Ахлах дасгалжуулагч	TYCB-5	2
12	Нярав	TY-4	1
13	Жолооч	TY-3	1
14	Сантехникч, цахилгаанчин	TY-2	1
15	Үйлчлэгч	TY-1	4
16	Жижүүр	TY-1	4
17	Гэрээт ажилтан	TY-1	2